



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 233

Улаанбаатар хот

### “Үндэсний давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь хэсэг, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтыг “Үндэсний давхар даатгал” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /гишүүн/-ын үүрэгт ажлаас 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөр чөлөөлсүгэй.
2. “Үндэсний давхар даатгал” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболдыг 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн томилсугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний чиг үүргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийж гүйцэтгэхийг З.Энхболдод даалгасугай.



Ч.ХҮРЭЛБААТАР

9767000451